

ВИЗ ОЛГОХ НӨХЦӨЛИЙГ ХӨНГӨВЧЛӨХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар
(цаашид “Талууд” гэх),

Хоёр улсын өнөөгийн найрсаг харилцааг улам хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлийг
удирдлага болгон,

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдэд виз олгох нөхцөлийг
хөнгөвчлөх замаар иргэд хоорондын харилцааг хөгжүүлэхийг эрмэлзэн,

Энэхүү виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх арга хэмжээ нь хууль бус цагаачлал
үүсгэх ёсгүйг хүлээн зөвшөөрч, түүнчлэн аюулгүй байдлын асуудалд онцгой
анхаарч,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Ерөнхий заалт

1. Энэхүү хэлэлцээрийн заалт нь гадаадын иргэд үйлдвэрлэл болон
хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг зохицуулж буй аль нэг Талын үндэсний хууль
тогтоомжийг хөндөхгүй.

2. Нэг Талын иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа зорчиж
буй улсын хууль тогтоомжийг сахин биелүүлэх үүрэгтэй.

3. Нэг Талын иргэд олон улсын зориулалттай хилийн боомтоор нөгөө Талын
нутаг дэвсгэрт орно /гарна/.

2 дугаар зүйл

Хүчин төгөлдөр баримт бичиг

1. Нэг Талын иргэд Тал тус бүрийн улсын хууль тогтоомж, энэхүү хэлэлцээр болон Талууд хоорондын харилцаанд үйлчилж буй олон улсын бусад хэлэлцээрийн дагуу виз авах шаардлагаас чөлөөлөгдөөгүй тохиолдолд нөгөө Талын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр баримт бичиг болон визтэй орох, дамжин өнгөрөх, гарах, оршин суух эрхтэй.

2. Талуудын эрх бүхий байгууллагууд хүчин төгөлдөр баримт бичгийн загварыг энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос гуч (30) хоногийн өмнө дипломат шугамаар солилцоно.

3. Талуудын эрх бүхий байгууллагууд урьд нь хэрэглэж байгаагүй баримт бичгийг шинээр хэрэглэх, эсхүл хүчин төгөлдөр баримт бичигт өөрчлөлт орох тохиолдолд энэ тухай харилцан мэдэгдэх бөгөөд шинэ баримт бичгийг хэрэглэж эхлэх болон хүчин төгөлдөр баримт бичигт орсон өөрчлөлт үйлчилж эхлэхээс 30 (гуч) хоногийн өмнө тэдгээрийн загварыг дипломат шугамаар солилцоно.

3 дугаар зүйл

Энгийн паспорт эзэмшигчдэд виз олгох

1. Талууд энгийн паспорт эзэмшигч нөгөө талын иргэдэд ер /90/ хүртэлх хоногийн хугацаанд тухайн улсын нутаг дэвсгэрт орох, оршин суух, гарах виз дотоодын хууль тогтоомжийн дагуу олгож болно.

2. Талууд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан виз эзэмшигч тухайн нутаг дэвсгэрт орсноос хойш ер /90/ хоногийн хугацаанд нөгөө Талын иргэдийг гадаадын иргэний бүртгэлийн үүргээс чөлөөлж болно.

4 дүгээр зүйл

Визийн хураамжаас чөлөөлөх

Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд дурдсан энгийн паспорт эзэмшигчийг визийн хураамжаас чөлөөлнө.

5 дугаар зүйл

Гадаадын иргэдийг гарах визээс чөлөөлөх

Нөгөө Талын нутаг дэвсгэр дээр оршин суудаг нэг Талын иргэн өөрийн оршин суух хугацаандаа нөгөө Талын нутаг дэвсгэрээс түр хугацаагаар гарах тохиолдолд гарах виз авах үүргээс чөлөөлөгдөнө.

6 дугаар зүйл

Дипломат болон албан паспорт эзэмшигчдийг харилцан визээс чөлөөлөх

1. Хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч аль нэг Талын иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрийн олон улсын зориулалттай хилийн боомтоор тухайн улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу визгүй орох, гарах, дамжин өнгөрөх эрхтэй.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтэрснээс хойш визгүйгээр ер /90/ хүртэлх хоногийн хугацаанд байх эрхтэй. Байх хугацааг нөгөө талын хууль тогтоомжийн дагуу сунгаж болно.

7 дугаар зүйл

Олон удаагийн орох виз

Талууд нөгөө Талын иргэдэд өөрийн хууль тогтоомжийн дагуу нэг /1/, гурав /3/ буюу тав /5/ хүртэлх жилийн хугацаатайгаар олон удаагийн орох виз олгож болно.

8 дугаар зүйл

Баримт бичгээ гэсэн тохиолдолд буцаж гарах

Нэг Талын иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа хүчин төгөлдөр баримт бичгээ гэсэн тохиолдолд нөгөө Талаас олгосон хүчин төгөлдөр баримт бичгээр ямар нэгэн визгүйгээр тухайн улсын нутаг дэвсгэрээс гарна.

9 дүгээр зүйл

Онцгой тохиолдолд визийн хугацааг сунгах

Нэг Талын иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрээс визэнд заасан хугацаандаа гарах боломжгүй давагдашгүй хүчин зүйл үүсч, энэ нь баримтаар болон бусад

зүйлээр нотлогдсон тохиолдолд визийн хугацааг тухайн улсын нутаг дэвсгэрээс гарч явах боломжтой болох хүртэл хугацаагаар үнэ төлбөргүйгээр сунгаж өгнө.

10 дугаар зүйл

Яаралтай тохиолдолд дамжин өнгөрөх

1. Нэг Талын эрх бүхий байгууллагууд онцгой хүчин зүйл (цаг агаарын таагүй нөхцөл, тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл г.м) бий болсноос шалтгаалж агаарын хөлгийн ослын буулт хийх, эсхүл хөлөг онгоц зогсоолд түр байрлах тухай агаарын хөлгийн багийн ахлагч, хөлөг онгоцны ахмад болон тээврийн компанийн төлөөлөгчийн хүсэлтийг үндэслэн гуравдагч улс руу, эсхүл гуравдагч улсаас өөрийн нутаг дэвсгэр руу зорчиж буй нөгөө Талын иргэдэд тухайн улсын нутаг дэвсгэрт 72 цаг хүртэлх хугацаанд визгүй байх зөвшөөрөл олгоно.

2. Талуудын эрх бүхий байгууллагууд дээр дурдсан иргэдэд тухайн улсын нутаг дэвсгэрт түр байх нөхцлийн талаар нэмэлт хязгаарлалт тавих эрхтэй.

11 дүгээр зүйл

Хэлэлцээрийн үйлчлэлийг түр зогсоох

Аль нэг Тал нийгмийн дэг журам сахиулах, үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн түр зогсоох эрхтэй. Энэ тухай шийдвэр хүчин төгөлдөр болохоос 48-аас доошгүй цагийн өмнө нөгөө Талдаа дипломат шугамаар мэдэгдэнэ.

12 дугаар зүйл

Маргаан шийдвэрлэх

Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэхтэй холбогдон Талуудын хооронд гарах аливаа маргааныг дипломат шугамаар харилцан зөвшилцөх, хэлэлцээ хийх замаар шийдвэрлэнэ.

13 дугаар зүйл

Төгсгөлийн заалт

1. Энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг харилцан биелүүлсэн тухайгаа Талууд мэдэгдэнэ. Энэхүү хэлэлцээр нь сүүлчийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш гуч /30/ хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү хэлэлцээрт Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

3. Энэхүү хэлэлцээрийг нөгөө Талд дипломат шугамаар бичгээр мэдэгдэл өгөх замаар дуусгавар болгож болно. Мэдэгдлийг хүлээн авснаас хойш ер /90/ хоногийн дараа хэлэлцээр дуусгавар болно.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТОЛЖ, энэхүү хэлэлцээрт Засгийн газраас өгсөн бүрэн эрхийн дагуу гарын үсэг зурав.

Энэхүү хэлэлцээрийг Сөүл хотноо 2012 оны 5 сарын 31-ны өдөр монгол, солонгос, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

